



**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦСОН НАМ, ЭВСЛИЙН  
СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАН**

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Улаанбаатар хот

2025 он

**АГУУЛГА**

НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ .....	3
1.1 Аудит хийх бүрэн эрх, үндэслэл:.....	3
1.2 Үндэслэл, зорилго:.....	3
1.3 Хамрах хүрээ:.....	3
1.4 Арга зүй: .....	3
ХОЁР. СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАН .....	4
2.1 Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлсэн сонгуулийн зардлын тайлан.....	4
2.2 Сонгуулийн зардлын санхүүжилт, гүйцэтгэл, үлдэгдэл .....	4
2.3 Сонгуулийн зардлын тайлан баталгаажуулалт, тайлагнал .....	6
ГУРАВ. НЭГ САЯ БА ТҮҮНЭЭС ДЭЭШ ТӨГРӨГИЙН ХАНДИВ ӨГСӨН ИРГЭН, ХОЁР САЯ БА ТҮҮНЭЭС ДЭЭШ ТӨГРӨГИЙН ХАНДИВ ӨГСӨН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН МЭДЭЭЛЭЛ	
3.1 Нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийн талаар.....	6
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ .....	6
ХАВСРАЛТ №1 .....	7

**Товчилсон үг**

АДБОУС            Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

## НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

### Аудитын нэр:

Нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвслийн сонгуулийн зардлын тайланг баталгаажуулах аудит.

### 1.1 Аудит хийх бүрэн эрх, үндэслэл:

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3, 57 дугаар зүйлийн 57.3-д заасны дагуу “Аудитын сэдэв батлах тухай” Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны 8 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2024 оны А/24, А/44 дүгээр тушаалыг тус тус үндэслэн аудитыг гүйцэтгэсэн.

### 1.2 Үндэслэл, зорилго:

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-д “Төрийн аудитын дээд байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлэх ...” гэж заасны дагуу Нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвслийн сонгуулийн зардлын тайланг хянаж нэгтгэн, дүнг холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, нийтэд мэдээллээ.

### 1.3 ХАМРАХ ХҮРЭЭ:

Нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвслийн аудитын хуулийн этгээдээр баталгаажуулан ирүүлсэн сонгуулийн зардлын тайлан, аудитын дүгнэлт, харилцагч банкны дансны хуулга бусад шаардлагатай баримт, материалуудыг хамруулсан. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нийт 10 нам, 1 эвсэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд 8 нам, 1 эвсэл оролцсон байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.5<sup>1</sup>-д заасны дагуу арилжааны банкнудаас нам, эвслийн сонгуулийн зардлын дансны хуулгыг ирүүлсэн байна.

### 1.4 АРГА ЗҮЙ:

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, АДБОУС 100-400, 4000 дахь заалтыг мөрдлөг болгож сонгуулийн зардлын тайланг хянах, нотлох баримтыг нягтлан шалгах, тулган баталгаажуулах, лавлагаа авах арга зүйг ашигласан.

<sup>1</sup> Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56.5. Сонгуулийн зардлын данс байршуулсан банкны захирал, эсхүл салбарын эрхлэгч уг дансны бүх гүйлгээний хуулгыг гаргаж, санал авах өдрөөс хойш 30 хоногийн дотор төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ.

<sup>2</sup> 56.3. Нам, эвсэл нь санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ.

<sup>3</sup> 57.2.3. Сонгуулийн санхүүжилт, түүний зарцуулалтад гарсан зөрчлийн талаар баримт бичиг үйлдэх, бүрдүүлэх, холбогдох байгууллагад хүргүүлэх;

<sup>4</sup> 6.22.нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн ..., 17.1 дүгээр зүйлийн 25, 27 дахь хэсэгт заасан зөрчил;

## **ХОЁР. СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАН**

### **2.1 Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлсэн сонгуулийн зардлын тайлан**

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу 10 нам 1 эвсэл сонгуульд оролцох хүсэлтээ гаргаж эрхээ авсан байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.3-д “Нам, эвсэл болон нэр дэвшигч нь сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг санал авах өдрөөс 20-оос доошгүй хоногийн өмнө Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад мэдэгдэж, бүртгүүлэх үүрэгтэй” бөгөөд Нийслэл дэх Төрийн аудитын газарт нийт 10 нам, 1 эвсэл данс нээлгэсэн болон бүртгүүлсэн мэдээллийг ирүүлсэн байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3<sup>2</sup>-д заасны дагуу Төрийн аудитын байгууллагад Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцсон нийт 10 нам, 1 эвсэл сонгуулийн зардлын тайлангаа аудитын хуулийн этгээдээр баталгаажуулан ирүүлсэн, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд дэвшсэн 8 нам, 1 эвслээс 4 нам, 1 эвсэл сонгуулийн зардлын тайлангаа аудитын хуулийн этгээдээр баталгаажуулан ирүүлсэн байна.

Нийслэл дэх Төрийн аудитын газарт 1 нам сонгуулийн зардлын данс нээлгээгүй талаар мэдэгдэл ирүүлсэн бол 3 нам ирүүлээгүй байна.*(Иргэний хөдөлгөөний нам, Сайн ардчилал иргэдийн нэгдсэн нам, Үнэн ба зөв нам)*

Сонгуулийн зардлын тайланг ирүүлээгүй намын жагсаалтыг Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.3<sup>3</sup>, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.22<sup>4</sup>-т заасны дагуу Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүллээ.

### **Аудитын илрүүлэлт**

*Санал авах өдрөөс хойш 45 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын байгууллагад хүргүүлээгүй. /Иргэний хөдөлгөөний нам, Сайн ардчилал иргэдийн нэгдсэн нам, Үнэн ба зөв нам/.*

### **2.2 Сонгуулийн зардлын санхүүжилт, гүйцэтгэл, үлдэгдэл**

Нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцсон нам, эвсэл нь нийт 2,419.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 2,412.5 сая төгрөгийг сонгуулийн үйл ажиллагаанд зарцуулж, 6.7 сая төгрөгийн харилцах дансны үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Сонгуульд оролцсон нам, эвсэл давхардсан тоогоор 8 хуулийн этгээдээс 63.0 сая төгрөг, 194 иргэнээс 1,435.7 сая төгрөг, нам, эвслээс оруулсан мөнгөн хөрөнгө 669.6 сая төгрөг, нийт 2,168.3 сая төгрөгийн хандив авч, нэр дэвшигч болон нам, эвслийн сонгуулийн данс хооронд шилжүүлсэн 251.0 сая төгрөг нийт 2,419.2 сая төгрөгийн мөнгөн болон мөнгөн бус орлогыг бүртгэж тайлагнасан байна.

Нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд  
оролцсон нам, эвслийн сонгуулийн зардлын тайлан

### Санхүүжилт

Нам, эвслийн сонгуулийн зардлын тайлангаарх нийт орлого 2,419.2 сая төгрөгийг орлогын ангиллаар харуулбал. Үүнд:

*Хүснэгт 1. Сонгуулийн зардлын санхүүжилт, эх үүсвэр /сая төгрөг/*

Орлогын ангилал	Мөнгөн хандив		Мөнгөн бус хандив		Нийт	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нам,эвслээс оруулсан мөнгөн хөрөнгө		669.6				669.6
Хуулийн этгээдийн хандив	7	53.0	1	10.0	8	63.0
Иргэний хандив	194	1,435.7			194	1,435.7
Нэр дэвшигч болон нам, эвслийн сонгуулийн данс хооронд шилжүүлсэн мөнгөн хөрөнгө		251.0				251.0
<b>Дүн</b>	<b>201</b>	<b>2,409.2</b>	<b>1</b>	<b>10.0</b>	<b>202</b>	<b>2,419.2</b>

### Зардал

Нам, эвсэл сонгуулийн үйл ажиллагааны зардалд нийт 2,412.5 сая төгрөг зарцуулснаас сонгуулийн зардалд 2,296.7 сая төгрөг, бусад зардалд 115.8 сая төгрөг зарцуулжээ. Үүнд:

*Хүснэгт 2. Сонгуулийн зардлын гүйцэтгэл /сая төгрөг/*

Зардлын ангилал	Мөнгөн дүн
<b>НИЙТ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,412.5</b>
<b>2.1 Сонгуулийн зардал</b>	<b>2,296.7</b>
2.1.1 сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах	522.6
2.1.2 нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар, дэлгэц байрлуулах зардал	37.0
2.1.3 намын далбааг гудамж талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах зардал	3.2
2.1.4 сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал	51.8
2.1.5 сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал	1,248.0
2.1.6 сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах	141.3
2.1.7 өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд материал нийтлүүлэх зардал	7.6
2.1.8 цахим орчин ашиглах зардал	285.2
<b>2.2 Бусад зардлын дүн</b>	<b>115.8</b>

### Аудитын илрүүлэлт

1. Сүхбаатар дүүргийн Ардчилсан нам зардлын дээд хэмжээг 1,020.9 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан.

2. Сонгинохайрхан дүүргийн Ардчилсан намын дансанд бэлэн мөнгөөр орсон орлогын эх үүсвэр тодорхойгүй 127.9 сая төгрөгийг зарцуулсныг дүгнэлт гаргасан аудитын хуулийн этгээд үнэн зөв илэрхийлэгдсэн гэж тайлагнасан.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.5-д “Сонгуулийн зардлын дансанд хуримтлагдах хөрөнгийн хэмжээнд тусгайлан хязгаар тогтоохгүй боловч тухайн сонгуулийн сурталчилгааны хугацаанд сонгуулийн зардлын данснаас зарцуулах зардлын хэмжээ нь энэ хуульд заасны дагуу тогтоосон сонгуулийн зардлын дээд хэмжээнээс хэтрэхгүй”, 53 дугаар зүйлийн

Нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвслийн сонгуулийн зардлын тайлан

53.5-д “Буцах хаяг нь тодорхойгүй хандивыг холбогдох хууль тогтоомжийн дагуу улсын орлогод буюу төрийн санд шилжүүлнэ”, 53.7-д “Бэлэн мөнгөөр хандив өгөх, авахыг хориглоно”, 56.4.1-д “Сонгуулийн зардлын дансанд орсон орлогын нийт хэмжээг энэ хуулийн 48.2-т заасан хөрөнгийн эх үүсвэр болон гүйлгээ тус бүрээр” бүрэн мэдээлнэ гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.3<sup>3</sup>, Зөрчил хянан шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.12<sup>4</sup>-т заасны дагуу хуулийн шаардлага хангаагүй хандивыг зарцуулсан, дансны үлдэгдэлтэй боловч буцаан шилжүүлээгүй нам, эвслийн жагсаалтыг Нийслэлийн Татварын газарт хүргүүлээ.

### **Сонгуулийн зардлын тайлан баталгаажуулалт, тайлагнал**

Нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн зардлын тайланд нийт 18 хуулийн этгээд аудит хийж Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3 дахь заалтын дагуу баталгаажуулан ирүүлсэн байна.

Аудитын хуулийн этгээдийн баталгаажуулсан давхардсан тоогоор 24 тайланд “үнэн зөв, иж бүрэн илэрхийлэгдсэн” гэсэн дүгнэлт өгсөн байна.

### **ГУРАВ. НЭГ САЯ БА ТҮҮНЭЭС ДЭЭШ ТӨГРӨГИЙН ХАНДИВ ӨГСӨН ИРГЭН, ХОЁР САЯ БА ТҮҮНЭЭС ДЭЭШ ТӨГРӨГИЙН ХАНДИВ ӨГСӨН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН МЭДЭЭЛЭЛ**

#### **3.1 Нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийн талаар**

Нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн 138 иргэний 265.8 сая, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн 7 хуулийн этгээдийн 63.0 сая төгрөг, нийт 328.8 сая төгрөгийн хандивыг Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-д заасны дагуу мэдээллийг нэгтгэв.

Иргэн, хуулийн этгээдээс өгсөн дээрх мөнгөн хандивын мэдээллийг [audit.mn](http://audit.mn) сайтад байршуулж, нийтэд ил тод мэдээллээ.

#### **ДӨРӨВ. ДҮГНЭЛТ**

Нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвслийн аудитын хуулийн этгээдээр баталгаажуулан ирүүлсэн сонгуулийн зардлын тайланг хянаж, дүнг нэгтгэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцсон нам, эвсэл нийт 2,419.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 2,412.5 сая төгрөгийг сонгуулийн үйл ажиллагаанд зарцуулж, 6.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.
2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-д заасны дагуу нийт 328.8 сая төгрөгийн хандивыг мэдээллээ.
3. Сонгуулийн зардлын дээд хэмжээг хэтрүүлсэн, орлогын эх үүсвэр тодорхойгүй хандивыг зарцуулсан 1,148.8 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

**Нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд  
оролцсон нам, эвслийн сонгуулийн зардлын тайлан**

**ХАВСРАЛТ №1**

**НЭГ САЯ БА ТҮҮНЭЭС ДЭЭШ ТӨГРӨГИЙН ХАНДИВ ӨГСӨН ИРГЭН, ХОЁР САЯ БА ТҮҮНЭЭС ДЭЭШ ТӨГРӨГИЙН ХАНДИВ ӨГСӨН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН**

/төгрөгөөр/

№	ТОЙРОГ		Нэр дэвшүүлсэн нам эвсэл	Хандив өгсөн иргэн болон хуулийн этгээдийн нэр	Иргэн / Нэг сая төгрөгөөс дээш/ Мөнгөн	Хуулийн этгээд /Хоёр сая төгрөгөөс дээш/ Мөнгөн	
					хандивын дүн	хандивын дүн	Мөнгөн бус хандивын дүн
А	Б	Б	Д	Е	1	2	3
1	Улаанбаатар	Сонгинохайрхан	Монгол ардын нам	Г.Отгонцэцэг	1,500,000.00		
2	Улаанбаатар	Сонгинохайрхан	Монгол ардын нам	Б.Мөнхжаргал	1,000,000.00		
3	Улаанбаатар	Сонгинохайрхан	Монгол ардын нам	Х.Мөнхтуул	2,000,000.00		
4	Улаанбаатар	Сонгинохайрхан	Монгол ардын нам	Г.Занданхүү	1,000,000.00		
5	Улаанбаатар	Сонгинохайрхан	Монгол ардын нам	О.Баяраа	2,000,000.00		
6	Улаанбаатар	Сонгинохайрхан	Монгол ардын нам	Г.Уранцэцэг	2,000,000.00		
7	Улаанбаатар	Сонгинохайрхан	Монгол ардын нам	О.Болор-Эрдэнэ	1,000,000.00		
8	Улаанбаатар	Сонгинохайрхан	Монгол ардын нам	Г.Бурмаа	2,000,000.00		
9	Улаанбаатар	Сонгинохайрхан	Монгол ардын нам	Д.Ганзориг	2,000,000.00		
10	Улаанбаатар	Сонгинохайрхан	Монгол ардын нам	Б.Хүслэн	2,000,000.00		
11	Улаанбаатар	Сонгинохайрхан	Монгол ардын нам	Г.Номинчимэг	2,000,000.00		
12	Улаанбаатар	Сонгинохайрхан	Монгол ардын нам	Н.Чимэддорж	2,000,000.00		
13	Улаанбаатар	Сонгинохайрхан	Монгол ардын нам	Г.Баянжаргал	2,000,000.00		
14	Улаанбаатар	Сонгинохайрхан	Монгол ардын нам	Б.Сүлд	2,000,000.00		
15	Улаанбаатар	Сонгинохайрхан	Монгол ардын нам	Гаяч ХХК			10,000,000.00
16	Нийслэл	Багахангай	Монгол ардын нам	Ц.Сандагдорж	2,000,000.00		
17	Нийслэл	Багахангай	Монгол ардын нам	Б.Аз-Эрдэнэ	1,500,000.00		
18	Нийслэл	Багахангай	Монгол ардын нам	Г.Соёлмаа	1,500,000.00		
19	Улаанбаатар	Хан-уул	Монгол ардын нам	Г.Батсайхан	2,000,000.00		
20	Улаанбаатар	Хан-уул	Монгол ардын нам	А.Амартүвшин	2,000,000.00		
21	Улаанбаатар	Хан-уул	Монгол ардын нам	Б.Хүрэлтогоо	2,000,000.00		
22	Улаанбаатар	Хан-уул	Монгол ардын нам	С.Сарангэрэл	2,000,000.00		
23	Улаанбаатар	Хан-уул	Монгол ардын нам	Ч.Бат-оргил	2,000,000.00		
24	Улаанбаатар	Хан-уул	Монгол ардын нам	Ц.Эрдэнэбаатар	2,000,000.00		
25	Улаанбаатар	Хан-уул	Монгол ардын нам	С.Батхишиг	2,000,000.00		
26	Улаанбаатар	Хан-уул	Монгол ардын нам	Т.Рэгзэдмаа	2,000,000.00		
27	Улаанбаатар	Хан-уул	Монгол ардын нам	Б.Амартүвшин	2,000,000.00		
28	Улаанбаатар	Хан-уул	Монгол ардын нам	Ч.Базарзаяа	2,000,000.00		
29	Улаанбаатар	Хан-уул	Монгол ардын нам	О.Ганхуяг	2,000,000.00		
30	Улаанбаатар	Хан-уул	Монгол ардын нам	М.Ганболд	2,000,000.00		
31	Улаанбаатар	Хан-уул	Монгол ардын нам	Д.Алимаа	2,000,000.00		
32	Улаанбаатар	Хан-уул	Монгол ардын нам	Д.Долгор	2,000,000.00		
33	Улаанбаатар	Хан-уул	Монгол ардын нам	Н.Дорждулам	2,000,000.00		

**Нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд  
оролцсон нам, эвслийн сонгуулийн зардлын тайлан**

34	Улаанбаатар	Хан-уул	Монгол ардын нам	С.Сайнбаяр	2,000,000.00		
35	Улаанбаатар	Хан-уул	Монгол ардын нам	Я.Энхбаатар	2,000,000.00		
36	Улаанбаатар	Хан-уул	Монгол ардын нам	Д.Мөнхжаргал	2,000,000.00		
37	Улаанбаатар	Хан-уул	Монгол ардын нам	Э.Насан-Очир	1,000,000.00		
38	Нийслэл		Ардчилсан нам	Х.Норов	2,000,000.00		
39	Улаанбаатар	Хан-уул	Үндэсний эвсэл	Б.Эрхэмбаяр	2,000,000.00		
40	Улаанбаатар	Хан-уул	Үндэсний эвсэл	Б.Ариун-Өлзий	2,000,000.00		
41	Улаанбаатар	Хан-уул	Үндэсний эвсэл	Б.Мөнгөнцэцэг	2,000,000.00		
42	Улаанбаатар	Хан-уул	Үндэсний эвсэл	Б.Батболд	2,000,000.00		
43	Улаанбаатар	Хан-уул	Үндэсний эвсэл	М.Энхсайхан	2,000,000.00		
44	Улаанбаатар	Хан-уул	Үндэсний эвсэл	П.Бямбадорж	2,000,000.00		
45	Улаанбаатар	Хан-уул	Үндэсний эвсэл	Б.Батсайхан	2,000,000.00		
46	Улаанбаатар	Хан-уул	Үндэсний эвсэл	Д.Отгон	2,000,000.00		
47	Улаанбаатар	Хан-уул	Үндэсний эвсэл	Н.Энхцэцэг	1,600,000.00		
48	Улаанбаатар	Хан-уул	Үндэсний эвсэл	Ц.Сэлэнгэ	2,000,000.00		
49	Улаанбаатар	Хан-уул	Үндэсний эвсэл	Я.Мягмарсүрэн	2,000,000.00		
50	Улаанбаатар	Хан-уул	Үндэсний эвсэл	Я.Эрдэнэчимэг	2,000,000.00		
51	Улаанбаатар	Хан-уул	Үндэсний эвсэл	Я.Эрдэнэтулга	2,000,000.00		
52	Улаанбаатар	Хан-уул	Үндэсний эвсэл	Я.Алтантулга	2,000,000.00		
53	Улаанбаатар	Хан-уул	Үндэсний эвсэл	Э.Баттунгалаг	2,000,000.00		
54	Улаанбаатар	Хан-уул	Үндэсний эвсэл	С.Энхбат	2,000,000.00		
55	Улаанбаатар	Хан-уул	Үндэсний эвсэл	Г.Ихбаяр	2,000,000.00		
56	Улаанбаатар	Хан-уул	Үндэсний эвсэл	Ц.Оюунцэцэг	2,000,000.00		
57	Улаанбаатар	Хан-уул	Үндэсний эвсэл	О.Өсөхбаяр	2,000,000.00		
58	Улаанбаатар	Хан-уул	Үндэсний эвсэл	Э.Жамьяандорж	2,000,000.00		
59	Улаанбаатар	Хан-уул	Үндэсний эвсэл	Ц.Оюунцэцэг	2,000,000.00		
60	Улаанбаатар	Хан-уул	Үндэсний эвсэл	Э.Болормаа	2,000,000.00		
61	Улаанбаатар	Хан-уул	Үндэсний эвсэл	Ө.Чулуунчимэг	2,000,000.00		
62	Улаанбаатар	Хан-уул	Үндэсний эвсэл	Д.Мягмарсүрэн	2,000,000.00		
63	Улаанбаатар	Хан-уул	Үндэсний эвсэл	О.Ихбаяр	2,000,000.00		
64	Улаанбаатар	Хан-уул	Үндэсний эвсэл	О.Энхбаяр	2,000,000.00		
65	Улаанбаатар	Хан-уул	Үндэсний эвсэл	С.Улаанцэцэг	2,000,000.00		
66	Улаанбаатар	Хан-уул	Үндэсний эвсэл	Э.Чулуунбаатар	2,000,000.00		
67	Улаанбаатар	Хан-уул	Үндэсний эвсэл	Б.Цэцэгжаргал	1,200,000.00		
68	Улаанбаатар	Хан-уул	Үндэсний эвсэл	Юнайтэд инженеринг ХХК		10,000,000.00	
69	Улаанбаатар	Хан-уул	Үндэсний эвсэл	Контонокс ХХК		10,000,000.00	
70	Улаанбаатар	Хан-уул	Үндэсний эвсэл	Эм ди даян ХХК		9,000,000.00	
71	Улаанбаатар	Хан-уул	Үндэсний эвсэл	Блюпринт солиушн ХХК		10,000,000.00	
72	Улаанбаатар	Хан-уул	Үндэсний эвсэл	Дөргөн угалз ХХК		10,000,000.00	
73	Нийслэл	Нийслэл	Хүн нам	Гэрэгэ эстимэйт үнэлгээ ХХК		3,960,000.00	

**Нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд  
оролцсон нам, эвслийн сонгуулийн зардлын тайлан**

74	Нийслэл	Чингэлтэй	Монгол ардын нам	Б.Анхжаргал	2,000,000.00		
75	Нийслэл	Чингэлтэй	Монгол ардын нам	Н.Ууганбаяр	2,000,000.00		
76	Нийслэл	Чингэлтэй	Монгол ардын нам	Д.Жамсрандорж	2,000,000.00		
77	Нийслэл	Чингэлтэй	Монгол ардын нам	Ү.Батсүрэн	2,000,000.00		
78	Нийслэл	Чингэлтэй	Монгол ардын нам	Б.Одгэрэл	2,000,000.00		
79	Нийслэл	Чингэлтэй	Монгол ардын нам	О.Эрдэмбат	2,000,000.00		
80	Нийслэл	Чингэлтэй	Монгол ардын нам	Ч.Дархансоёмбо	2,000,000.00		
81	Нийслэл	Чингэлтэй	Монгол ардын нам	О.Хонгорзул	2,000,000.00		
82	Нийслэл	Чингэлтэй	Монгол ардын нам	Т.Сарантуяа	2,000,000.00		
83	Нийслэл	Чингэлтэй	Монгол ардын нам	Х.Энх-Учрал	2,000,000.00		
84	Нийслэл	Чингэлтэй	Монгол ардын нам	Ч.Сарантөгс	2,000,000.00		
85	Нийслэл	Чингэлтэй	Монгол ардын нам	О.Өлзий	2,000,000.00		
86	Нийслэл	Чингэлтэй	Монгол ардын нам	Х.Өнөржаргал	2,000,000.00		
87	Нийслэл	Чингэлтэй	Монгол ардын нам	Х.Пүрэвсэнгэ	2,000,000.00		
88	Нийслэл	Чингэлтэй	Монгол ардын нам	Б.Дөлгөөн	2,000,000.00		
89	Нийслэл	Чингэлтэй	Монгол ардын нам	С.Янжмаа	2,000,000.00		
90	Нийслэл	Чингэлтэй	Монгол ардын нам	Г.Чингүн	2,000,000.00		
91	Нийслэл	Чингэлтэй	Монгол ардын нам	Д.Амарзаяа	2,000,000.00		
92	Нийслэл	Чингэлтэй	Монгол ардын нам	С.Туяа	2,000,000.00		
93	Нийслэл	Чингэлтэй	Монгол ардын нам	М.Лхамжав	2,000,000.00		
94	Нийслэл	Чингэлтэй	Монгол ардын нам	Э.Батбаатар	2,000,000.00		
95	Нийслэл	Чингэлтэй	Монгол ардын нам	А.Энх-Эрдэнэ	2,000,000.00		
96	Нийслэл	Чингэлтэй	Монгол ардын нам	Э.Рэнцэнжүгдэр	2,000,000.00		
97	Нийслэл	Чингэлтэй	Монгол ардын нам	О.Хулан	2,000,000.00		
98	Нийслэл	Чингэлтэй	Монгол ардын нам	Г.Заяаноров	2,000,000.00		
99	Нийслэл	Чингэлтэй	Монгол ардын нам	А.Энхцэцэг	2,000,000.00		
100	Нийслэл	Чингэлтэй	Монгол ардын нам	Д.Цэнд	2,000,000.00		
101	Нийслэл	Чингэлтэй	Монгол ардын нам	Ж.Батбаяр	2,000,000.00		
102	Нийслэл	Чингэлтэй	Монгол ардын нам	Б.Мөнх-Эрдэнэ	2,000,000.00		
103	Нийслэл	Чингэлтэй	Монгол ардын нам	Э.Отгонсүрэн	2,000,000.00		
104	Нийслэл	Чингэлтэй	Монгол ардын нам	Г.Ганцэцэг	2,000,000.00		
105	Нийслэл	Чингэлтэй	Монгол ардын нам	Д.Энхбаатар	1,200,000.00		
106	Нийслэл	Налайх	Монгол ардын нам	н.Эрдэнэцэцэг	2,000,000.00		
107	Нийслэл	Налайх	Монгол ардын нам	н.Цэрэнпагма	2,000,000.00		
108	Нийслэл	Налайх	Монгол ардын нам	н.Энхсайхан	2,000,000.00		
109	Нийслэл	Налайх	Монгол ардын нам	н.Отгонпүрэв	2,000,000.00		
110	Нийслэл	Налайх	Монгол ардын нам	н.Сонгууль	2,000,000.00		
111	Нийслэл	Налайх	Монгол ардын нам	н.Содномдаржаа	2,000,000.00		
112	Нийслэл	Налайх	Монгол ардын нам	н.Бэгзцэрэн	2,000,000.00		
113	Нийслэл	Налайх	Монгол ардын нам	н.Тунгалаг	2,000,000.00		

**Нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд  
оролцсон нам, эвслийн сонгуулийн зардлын тайлан**

114	Нийслэл	Налайх	Монгол ардын нам	н.Нямхүү	1,000,000.00		
115	Нийслэл	Налайх	Монгол ардын нам	н.Цэгмид	1,000,000.00		
116	Нийслэл	Налайх	Монгол ардын нам	н.Тунгалаг	2,000,000.00		
117	Нийслэл	Налайх	Монгол ардын нам	н.Цэнд	1,800,000.00		
118	Нийслэл	Налайх	Монгол ардын нам	н.Сэйтхан	2,000,000.00		
119	Нийслэл	Налайх	Монгол ардын нам	н.Чинбат	2,000,000.00		
120	Нийслэл	Налайх	Монгол ардын нам	н.Оюунчимэг	1,500,000.00		
121	Нийслэл	Баянзүрх	Үндэсний эвсэл	Э.Заягэгээ	2,000,000.00		
122	Нийслэл	Баянзүрх	Үндэсний эвсэл	Т.Нансалмаа	2,000,000.00		
123	Нийслэл	Баянзүрх	Үндэсний эвсэл	Л.Цэлмэгтэнгэр	2,000,000.00		
124	Нийслэл	Баянзүрх	Үндэсний эвсэл	И.Нарантуяа	2,000,000.00		
125	Нийслэл	Баянзүрх	Үндэсний эвсэл	Ж.Сүхболд	2,000,000.00		
126	Нийслэл	Баянзүрх	Үндэсний эвсэл	Н.Гэрэлмаа	2,000,000.00		
127	Нийслэл	Баянзүрх	Үндэсний эвсэл	Г.Амгалан	2,000,000.00		
128	Нийслэл	Баянзүрх	Үндэсний эвсэл	У.Болор	2,000,000.00		
129	Нийслэл	Баянзүрх	Үндэсний эвсэл	Б.Чинбат	2,000,000.00		
130	Нийслэл	Баянзүрх	Үндэсний эвсэл	Г.Ядамдорж	2,000,000.00		
131	Нийслэл	Баянзүрх	Үндэсний эвсэл	Б.Шүрмаа	2,000,000.00		
132	Нийслэл	Баянзүрх	Үндэсний эвсэл	П.Сэргэлэн	2,000,000.00		
133	Нийслэл	Баянзүрх	Үндэсний эвсэл	Б.Бадамдайрий	2,000,000.00		
134	Нийслэл	Баянзүрх	Үндэсний эвсэл	С.Жамъянсүрэн	2,000,000.00		
135	Нийслэл	Баянзүрх	Үндэсний эвсэл	Ч.Ганболд	2,000,000.00		
136	Улаанбаатар		Монгол ардын нам	н.Сумъяабазар	2,000,000.00		
137	Улаанбаатар		Монгол ардын нам	Ж.Батсайхан	2,000,000.00		
138	Улаанбаатар		Монгол ардын нам	Н.Сайнбуян	2,000,000.00		
139	Улаанбаатар		Монгол ардын нам	Н.Алтаншагай	2,000,000.00		
140	Улаанбаатар		Монгол ардын нам	Р.Дагва	2,000,000.00		
141	Улаанбаатар		Монгол ардын нам	Б.Саранчимэг	2,000,000.00		
142	Улаанбаатар		Монгол ардын нам	н.Одсүрэн	2,000,000.00		
143	Улаанбаатар		Монгол ардын нам	н.Гангамөрөн	2,000,000.00		
144	Улаанбаатар		Монгол ардын нам	н.Батсайхан	2,000,000.00		
145	Улаанбаатар		Монгол ардын нам	н.Энхцогт	2,000,000.00		
<b>Дүн</b>					<b>265,800,000.00</b>	<b>52,960,000.00</b>	<b>10,000,000.00</b>